

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2013 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ



**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОН БУСАД ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ
УЯЛДААГҮЙГЭЭС БОДИТ САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

Аудитыг гүйцэтгэсэн:
УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Дарга: С.Төмөрхүү

Чиглэлийн аудитын албаны менежер: Л.Эрдэнэчулуун

ЧАА-ны ахлах аудитор Ж.Эрдэнэ У.Баярмаа

ЧАА-ны аудитор Л.Авирмэд Ж.Оюунтуяа Р.Гончигцэрэн Б.Нямхүү Х.Энх-Амгалан Б.Буянхишиг

УАГ-ын харьяа аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээч нар

Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах, холбогдох саналаа өгөхийг хүсвэл 263755, 262451, 261805 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

*Үндэсний аудитын газар
 Чингэлтэй дүүрэг,
 Бага тойруу-3,
 Засгийн газрын IV байр
 Улаанбаатар хот 15160
 МОНГОЛ УЛС*

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл.....	4

Аудитын хураангуй

Оршил	6
▪ Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдал	6
▪ Сайжруулах асуудал	6

Бүлэг 1. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөлт оновчтой болоогүй, өмнөх жилээс тодорхой ахиц гараагүй байна

Оршил	7
▪ 2013 оны үндсэн чиглэлд бүтэц, агуулгын өөрчлөлт гараагүй, тодотгол хийгдээгүй байна	7
▪ 2013 онд эдийн засгийн бодит өсөлт гарна гэж төлөвлөжээ	9
▪ Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн төлөвлөлт хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдахгүй байна	9
▪ Бодлогоор дэмжигдсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт хангалтгүй, судалгаа тооцоонд үндэслэхгүй байна	10
▪ Зорилт, арга хэмжээний төлөвлөлтөд ХШҮ хийж байх шаардлагатай	14

Бүлэг 2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ бодитой үр дүнд хүрээгүй байна

Оршил	16
▪ Зорилтод хүрэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байна	16
▪ Чиг үүрэгтэй холбоотой арга хэмжээний зохион байгуулалт муугаас хэрэгжилт дутуу байна	18
▪ Зорилт, арга хэмжээний бэлтгэл ажилд хугацаа алдсаар байна	19
▪ ТЕЗ-дын хамтын ажиллагаа дутмагаас хэрэгжилтэд нөлөөлж байна	20
▪ Томоохон зорилт арга хэмжээний биелэлт хангагдаагүй байна	21

Агуулга

–Үргэлжлэл–

Бүлэг 3. Үндсэн чиглэлийн биелэлт, түүний тайлагнал ба үнэлгээгээр оролцогч талуудын хамтын ажиллагаа сул байна

Оршил	22
▪ ЭЗХЯ 2013 оны “Үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг 73.4 хувь гэж үнэлжээ	22
▪ Макро түвшний зарим үзүүлэлт бүрэн биелэгдээгүй байна.....	23
▪ Яамдын ХШҮ-ний нэгжээс хийсэн үнэлгээний дундаж 66.7 хувь байна	25
▪ ТЕЗ-дын үнэлгээ аудитаар 7.7 пунктээр буурч байна	25
▪ Бодит салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байна	26
▪ Үр дүнд чиглэсэн төлөвлөлтгүйгээс гүйцэтгэлд нөлөөлж байна	27
▪ Төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг үнэлэх үнэлгээний тогтолцоог шинэ түвшинд гаргах шаардлагатай	29
▪ Үндсэн чиглэлийн хэрэгжилттэй холбогдуулан гарсан шийдвэрийн биелэлт хангалтгүй байна	29
Аудит дүгнэлт	30
Аудитын зөвлөмж	31
Холбогдох байгууллагын санал:	
Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал	32
Хоёр. Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн санал	34
Саналд өгсөн тайлбар:	35
Монгол Улсын Ерөнхий аудиторын Тушаал	37
ХАВСРАЛТУУД:	
Хавсралт А “Үндсэн чиглэлийн хэрэгжсэн зорилт, арга хэмжээний жагсаалт”	38
Хавсралт Б “Үндсэн чиглэлийн хэрэгжилт дутуу зорилт, арга хэмжээний жагсаалт”	41
Хавсралт В “Үндсэн чиглэлийн 0-30 хувийн биелэлттэй зорилт, арга хэмжээний жагсаалт”	46
Хавсралт Г “Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт”	48

Товчилсон үгийн жагсаалт

АНАГ	Аймаг, нийслэлийн аудитын газар
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗТЯ	Зам, тээврийн яам
МШХХТГ	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ӨЧҮ	Өрсөлдөх чадварын үзүүлэлт
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ССАЖЯ	Соёл, спорт, аялал жуулчлалын яам
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХО	Хувийн хөрөнгө оруулалт
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
УУЯ	Уул уурхайн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ҮХЦБ	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ШСАА	Шадар сайдын ажлын алба
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитын бүрэн эрх, үндэслэл, зорилт

Аудитыг Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2014 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдлыг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд доорх чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Үндсэн чиглэлийн төлөвлөлт оновчтой хийгдсэн эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд зорилт, арга хэмжээний биелэлтийг хангахуйц үр нөлөөтэй ажлыг зохион байгуулсан эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд биелэлт, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж үр дүнг тооцсон эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх болон биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн ажлын албадыг хамруулав.

Салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын бүс орон нутагт хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг тэдгээрийн гаргасан тайлагналд үндэслэн ҮАГ-ын харьяа аймаг, нийслэл дэх аудитын газрууд үзэж танилцан тодруулга тайлбар ирүүлсэн болно.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас гаргасан биелэлтийн тайланд судалгаа хийж үнэлэх,
- Хөрөнгийн эх үүсвэрийн уялдааг судлах, гүйцэтгэлийг харьцуулах,
- Холбогдох төрийн байгууллагын албан тушаалтантай ярилцаж, асуулга, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл гаргуулан судлах,
- Яамдын хариуцсан арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэлсэн дотоод аудитын нэгжийн үнэлгээ, тайланг судлах,

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

- ҮАГ-аас 2011, 2012, 2013 онд хийсэн аудитын дүгнэлт, өгсөн зөвлөмж, санал асуулгын дүнг нягтлах, ярилцлага, харьцуулалт хийх,
- ТЭЗ бүрээр аудитын урьдчилсан тайланг бэлтгэж, хэрэгжилтийн байдлыг танилцуулах,
- Санхүү төсвийн асуудал болон хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан төрийн байгууллагуудаас гаргасан улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн статистик мэдээлэл, төрөөс баримтлах урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт материалд тулгуурлан судалгаа хийх,
- Аудитын хөтөлбөр, арга зүй, горимын дагуу цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн нотлох зүйлстэй тулган шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулах,
- Салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын бүс орон нутагт хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг тэдгээрийн гаргасан тайлагналд үндэслэн ҮАГ-ын харьяа аймаг, нийслэл дэх аудитын газрууд батлагдсан хөтөлбөр, аудитын арга зүй, горимын дагуу нотлох зүйлс цуглуулан судалгаа гарган, тодруулга хийх.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн аудитыг ҮАГ-ын ГАГ-ын болон АНАГ-ын аудитор, шинжээч нар гүйцэтгэв.

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын дагуу ЭЗХЯ-наас яамдын хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг үнэлж, тайланг ҮАГ-т ирүүлэх ажил удааширснаас аудитын нэгдсэн тайланг эцэслэн гаргах хугацаа хойшилсон болно.

Улсын Их хурлын чуулганы дэгийн тухай хууль, 2004 оны 2 дугаар тогтоолын дагуу Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг жил бүрийн эхний улиралд УИХ-д танилцуулахаар журамласан нь цаг хугацааны хувьд аудитыг гүйцэтгэх, нэгдсэн дүгнэлт гаргахад төлөвлөгөөт хугацаанд багагүй нөлөөлж байгаа бөгөөд мөн оны төсвийн болон хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, улсын нэгдсэн статистик дүн мэдээ эцэслэн гараагүй нь бодитой үнэлгээ, дүгнэлт гаргахад нөлөөлж байна.

Аудитын хураангуй

Оршил

Засгийн газраас улсын эдийн засаг нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хангуулах нэгдсэн төлөвлөгөө батлаагүй нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.

ЭЗХЯ-наас ТЕЗ-дын хариуцсан үндсэн чиглэлийн арга хэмжээний нэгдсэн үнэлгээг ҮАГ-т хугацаа хоцруулан ирүүлсэн байна.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдал

Үндсэн чиглэлд тусгагдсан нийт 166 арга хэмжээнээс ҮХЦБ-д шууд томъёологдсон байдлаар 73, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт шууд бус байдлаар 87 арга хэмжээ тусгагджээ.

Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд “66.7” хувь, ЭЗХЯ “73.4” хувь, ЗГХЭГ 67.1 хувь гэж үнэлжээ.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, арга зүйн дагуу хийсэн дүн шинжилгээ, үнэлгээний дүнгээр хэрэгжсэн 55, хэрэгжилт дутуу 101, хэрэгжээгүй 10 арга хэмжээ болж, хэрэгжилт “59.0” хувиар үнэлэгдэж байна. Өмнөх жилүүдтэй харьцуулахад хэрэгжсэн арга хэмжээ өсч дутуу болон хэрэгжээгүй арга хэмжээний тоо багасжээ.

Үндсэн чиглэлийн бодит салбарын хөгжлийн, байгаль орчин бүс нутгийн хөгжлийн, төрийн үйлчилгээ, засаглал эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт дутуу, хангалтгүй биелэлттэй байна. ЗГХЭГ, ШСАА, ҮАГ, БХБЯ, ЗТЯ, ЭХЯ, МТШХХГ, БОНХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх нийт 10 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Сайжруулах асуудал

Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөлтийн байдалд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж хэвшүүлэх шаардлагатай байна.

Баримт бичигт тусгагдсан томоохон зорилт, арга хэмжээг хэрэгжих хугацаа, хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан сонгодоггүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг оновчтой тооцдоггүй зөрчлүүд давтагдсаар байгаа нь зорилт, арга хэмжээний төлөвлөлтөд дорвитой шинэчлэл хийх шаардлагатайг харуулж байна.

ЗГХЭГ, ЭЗХЯ, бусад ТЕЗ-даас баримт бичгийн биелэлтийг хангахад гарч буй зардлын үр ашиг, үр дүнг тооцох арга зүйг боловсруулан ашиглах, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил үр дүнд хүрээгүй байна.

УИХ-аас үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан гаргасан шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, ТЕЗ-даас уг баримт бичиг, тавьсан зорилтод ач холбогдол өгч ажиллахгүй байна.

Оршил

1.1 “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийх аудитын зорилтыг хангахад 1 дүгээр дэд зорилтын хүрээнд уг баримт бичгийн төлөвлөлт, түүний үндэслэлд хэрхэн ач холбогдол өгч байгааг авч үзсэн бөгөөд төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй байна.

Тухайлбал, Үндсэн чиглэлийн төлөвлөлт оновчтой эсэхийг авч үзэхдээ түүнийг боловсруулахад хууль тогтоомжийн шаардлагыг баримтлан хэрэгжих үндэслэл, үр дүнг урьдчилан тооцсон, хамрах хүрээг оновчтой төлөвлөсөн, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур, хүрэх түвшин, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тооцоолол бодитой эсэхэд тулгуурлав.

1.2 ЭЗХЯ, ТЕЗ-даас үндсэн чиглэлийн төслийг боловсруулах, төлөвлөлтийн шатны ажилд үнэлгээ өгч, дүгнэлт гаргаж ажиллахгүй байна.

1.3 Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4-т заасныг үндэслэн ТЕЗ үндсэн чиглэлийн төслийг боловсруулж байна¹.

1.4 УИХ-аас үндсэн чиглэлийг эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий бодлогын хүрээний зорилтот арга хэмжээг хэрэгжүүлсэн байхаар баталсан ч Засгийн газраас “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаагүй байна.

2013 оны үндсэн чиглэлд бүтэц, агуулгын өөрчлөлт гараагүй, тодотгол хийгдээгүй байна

1.5 Мөн ЗГҮАХ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэйгээ² нийцүүлэн 2013 оны үндсэн чиглэлд ямар нэг өөрчлөлт, тодотгол хийгээгүй байна.

1.6 Яамдын үндсэн болон зайлшгүй гүйцэтгэх ажил үйлчилгээг үндсэн чиглэлд тусгасаар байгаа нь тухайн баримт бичгийн төлөвлөлт, боловсруулалтад шинэчлэлт хийх шаардлагатайг харуулж байна.

1.7 Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад зарчмын өөрчлөлт өмнөх жилүүдтэй харьцуулахад гараагүй байна.

1.8 Яамд уг баримт бичигт тусгах бодлогын зорилт, арга хэмжээний төслөө өмнөх тайлант жилдээ боловсруулж үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын 2004 оны 2 дугаар тогтоол¹

Журмын 1.2-т “... үндсэн чиглэл нь Монгол Улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн стратеги, хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн жилд төрөөс баримтлах бодлогыг тодорхойлсон баримт бичиг болно”

¹ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам”

² Засгийн газрын 2012 оны “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” 120 дугаар тогтоол

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталж, биелэлтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг бүтэн жилээр гаргаж, танилцуулахыг Засгийн газарт үүрэг болгожээ.

1.9 Үндсэн чиглэлийг яамдын саналд үндэслэн улсын хэмжээний урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүд, зарим хууль тогтоомжийн заалттай нийцүүлэн боловсруулжээ.

1.10 УИХ-аас баталсан улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 6 бодлогын хүрээний нийт 26 зорилт, 166 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгажээ.

Хүснэгт №1.1

Бодлогын хамрах хүрээ	УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоол	
	Зорилт	Арга хэмжээ
I. Өсөлтийн үр шимийг нийгмийн бүх бүлгүүдэд хүргэх макро эдийн засгийн бодлого	2	10
II. Бодит салбарын хөгжлийн бодлого	7	59
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого	3	18
IV. Хүнд өгөөжтэй нийгмийн бодлого	7	37
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэл	5	26
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах	2	16
Нийт	26	166

1.11 Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээний тоо 2012 оныхоос 14.5 хувиар өссөн байна.

1.12 Эдийн засаг, нийгмийн голлох зарим үзүүлэлтийг өмнөх жилүүдэд төлөвлөж байсантай харьцуулбал:

Хүснэгт №1.2

№	Зорилт, арга хэмжээний төлөвлөлт	Хүрэх түвшин /оноор/		
		2011	2012	2013
1	ДНБ-ий бодит өсөлт /%-уар/	8.2	16.6	19.0
2	Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ /ам.долл/	2076.5	3900.0	4930.0
3	Өрсөлдөх чадварын үзүүлэлт /нэгж/	0.758	3.9	4.0
4	Ажилгүйдлийн түвшин /%-уар/	2.9	6.8	6.1
5	Инфляцийн түвшин /%-уар/	9.7	9.0	8.0
6	ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх хувь	35.4	29.8	39.2
7	ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн зарлагын эзлэх хувь	40.4	36.5	41.2
8	ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь	5.0	6.7	2.0

2013 онд эдийн засгийн бодит өсөлт гарна гэж төлөвлөжээ

1.13 2013 онд ДНБ-ий өсөлт 19.0 хувьд, нийт хэмжээ 19 их наяд хүрэхээр буюу нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ өмнөх оны бодит өсөлтөөс нэмэгдэх, мөн инфляцийн түвшинг нэг оронтой тоонд байлгах, ажилгүйдлийг бууруулах, эдийн засгийн өсөлттэй холбоотой төсвийн зарим үзүүлэлтийн ДНБ-д эзлэх хувь өмнөх жилээс нэмэгдэх, төсвийн тухай хуулийн тусгай шаардлагад нийцүүлэн тэнцвэртэй байхаар төлөвлөжээ.

Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн төлөвлөлт хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдахгүй байна

1.14 Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг ашиглахаар баталсан байна.

Хүснэгт №1.3

/тбм.төг/

№	Эх үүсвэрийн ангилал	Үндсэн чиглэл /оноор/		
		2011	2012	2013
1	Улсын төсөв	357.8	1 964.5	2 108.6
2	Гадаад эх үүсвэр	81.7	198.3	367.8
3	Гадаадын хөрөнгө оруулалт	338.0	-	-
4	ТХХТ	2 091.8	440.5	697.0
5	Уул уурхайн орлого	513.0	-	-
6	Хувийн хөрөнгө оруулалт	-	952.2	615.7
7	Орон нутгийн төсөв	-	2.8	-
8	Хүний хөгжил сан	-	23.0	-
9	Гадаадын зээл, тусламж	183.7	-	-
10	Тусгай сан, бусад эх үүсвэр,	247.2	-	116.7
	ДҮН	3 813.2	3 581.3	3 905.8

1.15 Үндсэн чиглэлд батлагдсан санхүү, хөрөнгийн эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад 9.1 хувиар буюу 324.5 тэрбум төгрөгөөр, түүний дотор улсын төсвийн эх үүсвэр 44.1 хувь буюу 144.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж хөрөнгө оруулалтын 50 гаруй хувийг дотоод эх үүсвэрээр хангана гэж тооцоолсон байна.

1.16 Хөрөнгийн эх үүсвэрийн төлөвлөлт нь ихэвчлэн ТЕЗ-даас ирүүлсэн саналын төсөлд үндэслэгдэж байгаа бөгөөд үндсэн чиглэлд тусгагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болгодог.

1.17 Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад үндсэн чиглэлийн арга хэмжээний эх үүсвэрт 576.9 тэрбум төгрөг батлагдсан нь төлөвлөсөн эх үүсвэрийн 27.4 хувь болж байна.

1.18 Мөн уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж, олборлолтын үйл ажиллагаа 2013 онд эхлэн бодит салбар, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтад чиглэсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр эдийн засгийн бодит өсөлт гарахаар тооцсон байна.

1.19 Үндсэн чиглэлд тусгагдсан санхүү, хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай гэж санал болгосон зорилт, арга хэмжээний санхүүжилтийг улсын төсвөөс болон бусад эх үүсвэрийн тооцооллыг хийж баримтжуулсан, төлөвлөсөн тооцоо, судалгаа ихэнх яамдад алга байна.

1.20 Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагуудаас зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангахуйц санхүү, хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй гэдгээр төлөвлөлтийн алдаатай бодлоготой холбон тайлбарлаж байгаа боловч бусад нөөц, эх үүсвэрийг ашигласан талаар болон ямар нэг зохистой шийдэл, нөхцөл байдалтай уялдуулсан шийдвэр гаргаж ажиллаагүй байна.

Бодлогоор дэмжигдсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт хангалтгүй, судалгаа тооцоонд үндэслэхгүй байна

1.21 Үндсэн чиглэлд ТЭЗҮ, зураг төсөв бэлэн болоогүй, бэлтгэл хангагдаагүй, урт ба дунд хугацаанд хэрэгжих буюу хэрэгжих хугацаатай уялдуулаагүй, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр баталгаажаагүй, цаг хугацаа, хүчин чадал, нөөц, хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийг бодитой тооцолгүй төлөвлөснөөр хугацааны хувьд хэрэгжих үндэслэл саарч, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна.

Тухайлбал, “Бодит салбарын хөгжлийн бодлого”-ын хүрээний дараах арга хэмжээ үүнд хамаарч байна.

Эдийн засгийн хөгжлийн яам:

- 3.10-т Орчин үеийн “Өндөр технологийн үндэсний судалгааны төв” болон “Өндөр технологи, инновацийн хөрөнгө оруулалтын корпораци” төрийн өмчит ХХК-ийг байгуулах;
- 3.11-ийн Дархан-Сэлэнгийн бүс, Ховд аймагт шинжлэх ухааны парк байгуулах ажлыг эхлүүлэх;
- 18.4-ийн Үндэсний үйлдвэрлэгч ААН, компаниудын бүтээмж дээшлүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж, загвар компаниудыг бий болгох;

Барилга, хот байгуулалтын яам:

- 6.1-д Хонины ноосоор барилгын материал үйлдвэрлэх үйлдвэр барих;
- 3.4-т Барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулах, барилгын материалын лабораторийн сүлжээг бэхжүүлэх;
- 7.1-д Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах;
- 7.2-ын “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд 100 мянган айлын орон сууцыг барих ажлыг үргэлжлүүлэх зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингээр тодорхойлогдсон дэд арга хэмжээнүүд;
- 7.5-ын Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголын дагуу бүсчлэл, инженер геологи, газар хөдлөлийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах;
- 8.6-гийн Нийслэл, аймаг, орон нутгийн инженерийн дэд бүтцийг сайжруулах ажлыг үргэлжлүүлэх зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингээр тодорхойлогдсон дэд арга хэмжээнүүд;
- 24.5-ын Барилга байгууламжийг газар хөдлөлтөд турших лабораторитой болох, инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах;

Уул уурхайн яам:

- 3.2-ын зорилтын хүрээнд Тавантолгойн ордын Цанхийн зүүн хэсгийн уурхайг түшиглэн нүүрс баяжуулах үйлдвэрийг барих;
- 3.3-ын Газрын тос боловсруулах үйлдвэр барих;
- 3.9-ийн Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн төрийн мэдлийн агуулах, иж бүрэн шинжилгээний лаборатори барьж эхлэх;

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам:

- 3.1-ийн Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор, Багануур, Дарханы үйлдвэр-технологийн паркийн захиргааг байгуулах, ерөнхий төлөвлөгөө боловсруулах;
- 3.6-д Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах, нүүрснээс шингэн түлш, хий гаргах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах;
- 3.7-гийн Зүүн бүсийн холимог металлын ордын түүхийг эдийг боловсруулах үйлдвэр байгуулах судалгаа хийх;
- 5 ба 6 дугаар зорилтын хүрээний Хөдөө аж ахуйн салбарыг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэл, үр ашгийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэн хүн амын эрэлт хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, Хөнгөн хүнсний үйлдвэрлэлд шинэ техник, технологийг нутагшуулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн кластерүүдийг хөгжүүлэх;

Зам тээврийн яам:

- 8.1-ийн Стратегийн орд газруудыг холбосон төмөр замын сүлжээг барьж байгуулах, төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- 8.4-ийн Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд барих 545.6 км авто замын барилгын ажил;
- 8.7-гийн Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн шинэ төрөл систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх;
- 8.8-ын Нийтийн тээврийн үйлчилгээнд “JEA-800F” загварын дуобус үйлдвэрлэн гаргах;
- 8.9-ийн Даланзадгадын Гурвансайхан олон улсын нисэх буудлын барилгын ажлыг эхлүүлэх;

Эрчим хүчний яам:

- 8.11-ийн Эрчим хүчний салбарыг зах зээлийн зарчмаар ажиллуулах;
- 8.12-ын “ДЦС-5”-ын барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь;
- 8.14-ийн Улаанбаатар хотын гэр хорооллыг барилгажуулах хүрээнд цахилгаан хангамжийн дэд бүтцийг барьж байгуулах, шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн зураг төсөл боловсруулах;
- 8.16-гийн шинээр дулааны станц, дулааны шугам 3 аймагт барих;
- 8.17-гийн Сэлэнгэ мөрний сав газарт 300-350 МВт-ын том чадлын усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлэх;

1.22 Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан ч зорилтот түвшин, хэмжигдэхүйц байх харгалзах үзүүлэлт, үр дагаврын хамрах хүрээг үндэслэлтэй тооцолгүй ерөнхий байдлаар төлөвлөлт хийгдэж байгаа нь цаашид төлөвлөлтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хүлээгдэж буй үр дүнг бодитой тооцох, хариуцаж буй асуудлыг нээлттэй болгож, байгууллагын ажлын зохион байгуулалтыг сайжруулах шаардлага тавигдаж байна.

1.23 Яамдын хэмжээнд үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан гаргахдаа зорилт, арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг бууруулан төлөвлөсөн байна.

1.24 ҮХААЯ-наас “Сэлгээнд оруулах тариалангийн талбайн хэмжээ”-г 50.0 мянган га-гаас 20.0 мянган га, “Ургамал хамгаалал хийгдэх талбайн хэмжээ”-г 200.0 мянган га-гаас 60.0 мянган га, “Ойн зурвасын тариалангийн талбайн хэмжээ”-г 2.0 мянган га-гаас 0.1 мянган га, “Шинээр барих өвлийн хүлэмжийн багтаамж”-ын 20.0 мянган м.кв-г 0.8 га, “Нано технологийн төв лаборатори байгуулах ТЭЗҮ-ийн тоо”-г 2-1, “Шинээр барих арьс ширний үйлдвэрийн тоо”-г 3-1 болгох зэргээр хүрэх түвшинг бууруулан баталжээ.

1.25 БШУЯ-ны хариуцсан Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх арга хэмжээ 2011 оноос эхлэлтэй бөгөөд 2012 онд хотхоны байр зүйн зураглал зохиох, инженер геологийн судалгаа хийгдэж, 2013 онд хотхоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар, ТЭЗҮ боловсруулагдаагүй, газрын асуудал шийдэгдээгүй байхад барилга барихаар төлөвлөсөн нь хөрөнгө оруулалтыг төлөвлөх журмыг зөрчсөн, олон жил дамнаж гүйцэтгэл удааширч хөрөнгө санхүүгийн үргүй зардал гарч байна.

1.26 ЭЗХЯ цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан зэрэг бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй арга хэмжээ төлөвлөгдсөнийг өөрчлөх, хүчингүй болгох тухай УУЯ-наас гаргасан саналыг Засгийн газарт уламжилж шийдвэрлээгүйгээс хэрэгжилтийн байдалд нөлөөлсөн байна.

1.27 ЭБЭХС-ын /хуучнаар/ 2012 оны а/1722 дугаартай албан бичгээр зорилт 3.9-ийн хүрэх түвшин, үр дүнг “3 агуулах 105 мянган м³” гэснийг “1 агуулах 45.0 мянган м³” гэж, зорилт 3.2-ыг “Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн судалгааг хийж үйлдвэрийг барьж эхлэх” гэж, зорилт 3.8-ын “Нүүрсний туршилт судалгааны төв лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж өргөжүүлэх” гэж өөрчлөх, мөн 2013 оны 1/54 дугаартай албан бичгээр зорилт 3.6, 4.3, 10.3, 11.1, 18.4, 20.5 дах арга хэмжээг хасуулах саналаа тус тус хүргүүлсэн ч шийдвэрлээгүй байна.

1.28 Зам тээврийн сайдын хариуцах асуудлын хүрээнд нийт 1563.6 км хатуу хучилттай автозамыг улсын төсвийн 390.0, нийслэлийн автозамын сангийн 63.1, гадаад эх үүсвэр 111.4, МУХБ-ны 193.9 буюу нийт 758.4 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг ашиглахаар төлөвлөсөн байна.

1.29 Төлөвлөлтийн шатанд гаргасан саналаа хүрэх үр дүнтэй нь холбон тусгах асуудлыг үндсэн чиглэлийг боловсруулах явцад яам, агентлагаас төдийлөн авч үздэггүйгээс хэрэгжүүлэлтийн шатанд үр дүн бага гарахад хүргэж байна.

1.30 ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зарим томоохон арга хэмжээнүүд төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Тухайлбал,

- *Үндсэн чиглэлийн 13.6-д Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор концессын жагсаалтад сургуулийн сурагчдын үдийн хоолны хүнсний комбинатыг “барих-өмчлөх-ашиглах” хэлбэрээр баталсан ч ерөнхий төлөвлөгөө боловсруулах, зургийн даалгавар, ТЭЗҮ боловсруулагдаагүй, суурь судалгаа хийгдээгүй байсан;*
- *3.6.1-ийн олон жил дамнаж байгаа Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах;*
- *3.7-д Зүүн бүсийн холимог металлын ордын түүхийг эдийг боловсруулах үйлдвэр байгуулах судалгаа хийх;*
- *6.1.4-ийн Паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хөнгөн үйлдвэрт шинэ, дэвшилтэт техник, технологи нутагшуулах, нэвтрүүлэх;*
- *6.2.1-ийн Үйлдвэрлэл технологийн паркийн бүсийн кластер, хөнгөн үйлдвэрийн туршилтын үйлдвэрийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах арга хэмжээнүүд санхүүгийн эх үүсвэр тодорхойгүйн улмаас бүрэн хэрэгжсэнгүй.*

1.31 ЭЗХЯ бусад яамдаас ирүүлсэн саналыг үндсэн чиглэлийн төсөлд тусгахдаа судалгаа тооцоонд үндэслэн дахин нягтлан боловсруулж, төлөвлөлтөд үнэлгээ хийн үр дагавар, хамрах хүрээг бодитой төлөвлөх зэргээр төлөвлөлтийн бодлогод шинэчлэл хийх шаардлагатай болжээ.

1.32 Мөн хэрэгжилтийн үндэслэлийг сайжруулахын тулд төлөвлөлтийн шатанд яамдад бодитой чиглэл өгч, төлөвлөлтөд ач холбогдол өгөх зэрэг хамтын ажиллагаа дутагдалтай байна.

1.33 Нийт төлөвлөсөн зорилт арга хэмжээнээс 50-аас доош хувийн биелэлттэй байгаа асуудлын нийтлэг шалтгааныг авч үзвэл:

- *Төлөвлөлтийн алдаа, шалгуур, хэмжих нэгж, хүрэх түвшинг бодитой тодорхойлоогүй 6.6 хувь буюу 11,*
- *Төсөв хөрөнгө хүрэлцээгүйгээс 25.9 хувь буюу 43,*
- *Хэрэгжүүлэх нөөц, цаг хугацааны боломж хомс байдлаас 22.2 хувь буюу 37,*
- *Хамтран хэрэгжүүлэгчээс шалтгаалсан 18.6 хувь буюу 31,*
- *Бэлтгэл ажлыг хангаж чадаагүй 13.8 хувь буюу 23,*
- *Бусад шалтгаанаар 12.6 хувь буюу 21 байна.*

Зорилт, арга хэмжээний төлөвлөлтөд ХШҮ хийж байх шаардлагатай

1.34 Үндсэн чиглэлийн бүтэц агуулгыг шинэчлэх шаардлага, үндэслэлийг санал асуулгын 8 үзүүлэлтээр авч, өмнөх санал асуулгын дүнтэй харьцуулан үзэхэд “Тийм” гэсэн хариултын хувь хэмжээ өссөн нь хэрэгцээ шаардлага, үндэслэл хэвээр хадгалагдаж байгааг илэрхийлэхээс гадна цаашид шинэчлэл шаардагдаж буйг харуулж байна.

Шигтгээ 1

№	Хариултын хувилбар	“Тийм” гэсэн хариулт, /хувиар/		Өөрчлөлт /+;-/
		2011 он	2013 он	
1	Улсын хөгжлийн стратеги, дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигт тодорхойлогдсон үндсэн асуудал агуулгын хувьд орхигдох, огт тусгагдахгүй байх	8.1	22.4	14.3
2	Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхүйц нөөцийг үнэлж, үнэлгээ хийгдэхгүй байх	35.4	40.5	5.1
3	Хэрэгжилтийг хангах үүрэг бүхий хариуцагч, хэрэгжүүлэгч байгууллагыг зөв тодорхойлоогүй байх	9.1	31.4	22.3
4	Үндсэн чиглэлд тусгагдах зорилтуудын хэрэгжилтийг хангахуйц, тохирсон зөв арга хэмжээ тодорхойлогдохгүй байх	17.3	30.7	13.4
5	Үндсэн чиглэлийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойлогдоогүй байх	26.3	41.5	15.2
6	Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, биелэлтийн байдлыг үнэлж, дүгнэхгүй, хариуцлагын тогтолцоо сул хөгжсөн байх	25.3	38.7	13.4
7	Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах талууд хоорондын харилцаа, түүний тайлагнал, хүлээх хариуцлага орхигдох	20.6	40.2	19.6
8	Үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангах чиглэлээр хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд зайлшгүй өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлагатай	24.2	55.1	30.9

Тодруулга: 2012 онд³ “Тийм” буюу хэрэгцээ байгаа гэсэн үнэлгээг нөөцийг үнэлж, үнэлгээ хийгддэггүй гэсэн хариултын хувь 35.4 хувь байсан бол санал асуулгаар 40.5 хувь, хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойлогдохгүй 26.3 хувиас 41.5 хувь, биелэлтийг үнэлж дүгнэхгүй, хариуцлагын тогтолцоо сул хөгжсөн 25.3 хувиас 38.7 хувь, уг баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах эрх зүйн хүрээнд өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлагатай 24.2 хувиас 55.1 хувь болж тус тус өссөн бөгөөд санал асуулга тус бүрт эзлэх хувийн жин нэмэгдсэн байна.

Санал асуулгад Ерөнхий сайдын багцад хамаарах газрууд болон Сангийн яам, ЭЗХЯ, ҮХААЯ, БХБЯ, УУЯ, ЭХЯ, БШУЯ, ХЗЯ, ЭМЯ, ХАХНХЯ-ны ажилтнууд хамрагдсан байна.

1.35 Зорилтуудын хэрэгжилтийг хангахуйц, тохирсон зөв арга хэмжээ тодорхойлогдохгүй байгаа гэсэн хариултад “Тийм”, “Түгээмэл” гэж үзэгсэд Сангийн яамны оролцогчдын 50.0 хувь, БХБЯ-ны оролцогчдын 62.5 хувь, УУЯ-ны оролцогчдын 63.6 хувь, ХЗЯ-ны 35.3 хувь нь энэ тал дээр анхаарах хэрэгтэй гэдэгтэй илүү санал нийлж байна.

1.36 Хэрэгжилт, биелэлтийг үнэлж дүгнэхгүй, хариуцлагын тогтолцоо сул гэсэн үзүүлэлтэд Сангийн яамнаас оролцогчдын 50.0 хувь, БХБЯ-наас оролцогчдын 81.8 хувь, УУЯ-наас оролцогчдын 52.9 хувь, ҮХААЯ-наас оролцогчдын 71.4 хувь нь энэ дутагдал түгээмэл байгаа гэж хариулсан байна.

³ “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудит

1.37 Үндсэн чиглэлд тусгагдсан зарим зорилт, арга хэмжээний агуулга цар хүрээнээсээ хамаараад хэд хэдэн он дамжин хэрэгжих, хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй асуудал гарах, оны эхэнд зорилт, арга хэмжээнд өөрчлөлт оруулах байсан зэрэг асуудал хариулагдсан байна.

Шигтгээ 2

Та “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн онцлогийг тэмдэглэнэ үү?” гэсэн асуулга, судалгааны дүнгээс үзэхэд:		Хувь
2012 оноос	Үндсэн өөрчлөлт гарсан	19.0
	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд бараг өөрчлөлтгүй	38.0
	Огт өөрчлөгдөөгүй буюу давтагдсан	15.0
	Хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд зайлшгүй өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлагатай	28.0
2013 оны хувьд	Салбарын хувьд хэрэгжих боломжтой	22.7
	Салбарын хувьд хэрэгжилтэд шүүмжлэлтэй хандана	18.2
	Зохих өөрчлөлтийг оны эхэнд хийх шаардлагатай байсан	20.1
	2013 ондоо багтаан хүндрэлтэй зарим зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нөхцөл байдлыг үнэлж судлан агуулга, шалгуур, үнэлэх хэмжүүрийг өөрчлөх зэрэг шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсан	20.1
	Үндсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, үүссэн нөхцөл байдлыг харгалзаж үзэх, түүнийг шийдвэрлэх боломж бололцоо нөөц байгаагүй	18.9
2014 онд	2013 онд шийдвэрлэгдээгүй, хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ 2014 оны үндсэн чиглэлд давтагдсан	64.2
	2015 оны үндсэн чиглэлд давтагдах хандлагатай	35.8

Тодруулга: 2010 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн аудитаар⁴ тухайн жилийн “Үндсэн чиглэл” нь онцлогийн хувьд өмнөх жилийнхтэй харьцуулахад тухайн салбарын хувьд шүүмжлэлтэй хандах, нөхцөл байдлыг үнэлэн зарим өөрчлөлт хийх байсан гэдэгтэй санал нийлж, анхаарал хандуулж байсан байна.

2013 оны үндсэн чиглэлийн тухайд авч үзвэл оны эхэнд зохих өөрчлөлтийг хийх, тухайн салбарын хувьд шүүмжлэлтэй хандсан, хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх нөөц боломж хомс байсан гэдэг хариултыг түлхүү өгсөн байна. Мөн хэрэгжилт дутуу болон зайлшгүй хэрэгцээ шаардлагатай гэж тооцохуйц арга хэмжээ 2014 оны үндсэн чиглэлд тусгагдсан гэж дийлэнх оролцогчид үзсэн байна.

1.38 Аудитын явцад санал асуулгад оролцогчдын албан тушаал, чиг үүргийн хамаарлыг авч үзвэл:

Шигтгээ 3

Агуулга	Санал асуулгад оролцогчдын албан тушаал, Үүнээс:	Оролцооны хувь	
		2011 он	2013 он
Үндсэн чиглэлийн төслийг боловсруулах ба төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үнэлгээ тайлагнах үе шатны ажлын оролцоо ба хамаарал:	■ Үндсэн чиглэлийг анхан шатанд боловсруулах, төлөвлөлтийн үндэслэлийг хариуцах түвшний	57.1	17.7
	■ Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, зохион байгуулалтыг хариуцах түвшний	26.2	66.6
	■ Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд /улс, ард нийтийн хэрэгцээ/ тайлагнал, үр дүнг хариуцах түвшний	16.7	15.7

Тодруулга: Санал асуулгад үндсэн чиглэлийн төлөвлөлтийн үндэслэлийг хариуцах түвшний оролцогчдын тоо буурсан ч хэрэгжилт, зохион байгуулалтыг хариуцах түвшний оролцогчдын тоо өмнөх үеийнхээс 2.5 дахин өссөн, хэрэгжилт, тайлагналыг хариуцах түвшний оролцогчдыг хамарсан түүврийн хэмжээ ойролцоо хэмжээнд байсан болно.

⁴ “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудит

Оршил

2.1 Аудитын 2 дугаар дэд зорилт нь “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд зорилт, арга хэмжээний биелэлтийг хангахуйц үр нөлөөтэй ажлыг зохион байгуулж чадсан эсэхийг тодорхойлох хүрээнд дараах асуудлыг дэвшүүлэв. Үүнд:

- *Хэрэгжүүлэгч байгууллагууд зорилтод хүрэх зохион байгуулалтын арга хэмжээг хугацаанд нь авч, хэрэгжүүлж үр дүнд хүрсэн үү?*
- *Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж чадсан уу?*
- *Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарсан хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж ажилласан эсэх?*

Зорилтод хүрэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байна

2.2 Засгийн газраас эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө гаргаж батлаагүйгээс зарим яамдын түвшинд арга хэмжээний хариуцагч байгууллага, албан тушаалтнуудын ажлын хариуцлага, хамтын ажиллагааны уялдаа сул байна. Яамд жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээг тусган хэрэгжүүлдэг байна.

2.3 Сангийн яам, ЭХЯ, БХБЯ, ХЗЯ, ҮХААЯ, ХАХНХЯ, БОНХЯ, ССАЖЯ үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хариуцах нэгж, албан тушаалтны хуваарийг батлан тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтийг хариуцах газруудыг тодорхой болгосон байна.

2.4 ЭЗХЯ, ЗТЯ, ЭМЯ, БШУЯ, УУЯ, ГХЯ, Хөдөлмөрийн яам үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаагүй, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгажээ.

2.5 Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын дагуу 2013 оны үндсэн чиглэлийн биелэлтийг Сангийн Яамнаас бусад яамд ЭЗХЯ-нд хугацаа хэтрүүлэн хүргүүлсэн ба ССАЖЯ хугацааг олон хоногоор хэтрүүлж, БШУЯ, ШСАА, СЗХ, ҮАГ, ШЕЗ, УБЕГ зэрэг байгууллагууд хэрэгжилтийн байдалдаа үнэлгээ хийлгүйгээр хүргүүлсэн байна.⁵

2.6 Үндсэн чиглэлийн 20.2-т “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийн асуудал хариуцсан түр зөвлөлийг байгуулж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах” гэсэн зорилтыг ЗГХЭГ-аас Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3-т зааснаар⁶ УИХ шийдвэрлэх тул уг асуудлыг Засгийн газар шийдвэрлэх боломжгүйгээс хэрэгжээгүй байна.

⁵ Засгийн газрын 2013 оны 322 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3-т “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ”

2.7 БХЯ болон ХХЕГ хариуцан хэрэгжүүлэх зарим арга хэмжээ нууцын зэрэглэлтэй гэснээр үнэлгээнд бодитой хамрагдаагүй бөгөөд хэрэв тухайн арга хэмжээ, асуудал нь хуулиар зохицуулагдсан нууцын зэрэглэлтэй тохиолдолд үндсэн чиглэлд тусгах биш яамны үйл ажиллагааны дотоод төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжилтийг зохих журмын дагуу холбогдох шатанд тайлагнах нь зүйтэй.

2.8 ҮХААЯ-наас хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн тоо хэмжээг бууруулан хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө баталсан ч тэдгээр арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал,

- Төлөвлөгөөний 5.3.5-д тусгагдсан арга хэмжээний ажлын үнэлгээ 70 хувийн;
- 5.10-т тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт 30 хувийн;
- 5.11.2-т тусгагдсан арга хэмжээ 30 хувийн;
- Мөн 6.2.1, 6.1.4-т тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт тус тус 30 хувийн биелэлттэй байна.

2.9 Зам, тээврийн салбарт 1563.6 км хатуу хучилттай автозам шинээр ашиглалтад оруулахаар төлөвлөснөөс дараах 1017.3 км авто замыг ашиглалтад оруулж, 546.3 км зам баригдаагүй байна.

Хүснэгт № 2.1

Баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Хүрэх үр дүн	Эх үүсвэр	Тайлбар
Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-3, АН-4 чиглэлийн авто замыг барьж байгуулах;	Чойр-Замын-Үүд чиглэлд ашиглалтад оруулах авто зам	300	69.23 ГЭҮ, Улсын төсөв	Ашиглалтад орсон -300 км
	Ярант - Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлд ашиглалтад оруулах авто замын урт	213.8	42.2 ГЭҮ, улсын төсөв	Хэрэгжээгүй
Аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох, Мянганы зам төслийг үргэлжүүлэн хэрэгжүүлэх;	Ашиглалтад оруулах авто замын урт	826	390.0 Улсын төсөв	Ашиглалтад орсон-533.8 км 292.2 км зам баригдаагүй
	Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд барих 545.6 км авто замын барилгын ажлын хэрэгжилт /30 хувь/	163.7	193.9 МУХБ	Бүрэн хэрэгжсэн
Улаанбаатар хотод шинээр авто зам, гүүрэн гарц барих, өргөтгөх ажлыг зохион байгуулах;	Шинээр барих авто замын урт	60.1	63.1 Нийслэлийн авто замын сан	Ашиглалтад орсон - 19.8 км
				Ашиглалтад ороогүй - 40.3 км
Дүн		1563.6		Ашиглалтад орсон 1017.3 км Ороогүй 546.3 км

Чиг үүрэгтэй холбоотой арга хэмжээний зохион байгуулалт муугаас хэрэгжилт дутуу байна.

2.10 ЭЗХЯ болон бусад яамд газруудтай хамтарч хариуцан хэрэгжүүлэх 12 үндсэн арга хэмжээнээс бодит салбарын хөгжлийн болон хүнд өгөөжтэй нийгмийн бодлогын хүрээний зарим арга хэмжээний биелэлт, үр дүн муу байгаа нь үндсэн чиг үүрэгтэй холбоотой гол зорилтоо хангуулах талаар хамтарсан, зохион байгуулалттай ажил хангалтгүйг харуулж байна. Тухайлбал,

- 1.5-ын Эдийн засгийн өндөр өсөлтийг дэмжих томоохон төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, гадаад худалдааны алдагдлыг бууруулах, гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 495.7 сая ам.доллар буюу 4.5 хувь, экспорт 112.0 сая ам.доллар буюу 2.6 хувь, импорт 383.7 сая ам.доллар буюу 5.7 хувиар буурсан байна.
- 3.10-ын Орчин үеийн “Өндөр технологийн үндэсний судалгааны төв” болон “Өндөр технологи, инновацийн хөрөнгө оруулалтын корпорац” Төрийн өмчит ХХК-ийг байгуулах хүрээнд ЭЗХЯ-ны ТНБД-ын 2013 оны 96 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулж журмын төсөл болон танилцуулга боловсруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн, журмын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг л хийсэн.
- 3.11-ийн Дархан-Сэлэнгийн бүс болон Ховд аймагт шинжлэх ухааны парк байгуулах ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд 2012 онд зарлагдсан Ховд аймаг болон Дархан-Сэлэнгийн бүсэд шинжлэх ухааны парк байгуулах боломжийн талаарх ТЭЗҮ-ийн урьдчилсан судалгааг хүлээн авснаар хийсэн ажил хязгаарлагджээ.
- 18.4-ийн Үндэсний үйлдвэрлэгч ААН, компаниудын бүтээмж дээшлүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж, загвар компаниудыг бий болгох зорилгоор Ноос, ноолуур боловсруулах Говь, Эрдэнэт хивс, Гоёо, Алтай кашмер, Хатан сүлжээ, Нанс кашмер, Гурван сор, Эко ноос зэрэг компаниудыг загвар компани болгохоор ажиллаж байгаа боловч ажлын биелэлт 30 хувьтай байна.
- 25.3-ын Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага “АПЕК”-д элсэх чиглэлээр үргэлжлүүлэн идэвхтэй ажиллах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: 2013 онд АПЕК-ийн гишүүн орнуудтай 9.2 тэрбум ам.долларын худалдаа хийсэн нь 2012 оны мөн үетэй харьцуулахад 6.7 хувиар буурсан, 2013 оны 10 сарын байдлаар АПЕК-ийн гишүүн орнуудаас манай улсад 148.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 83.2 хувиар буурсан байна.

Зорилт, арга хэмжээний бэлтгэл ажилд хугацаа алдсаар байна

2.11 Засгийн газрын бодлогын зарим зохицуулалтаас шалтгаалан ЗТЯ-ны хэрэгжүүлэх зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт зогсонги байдалд орсон байна. Тухайлбал,

- 8.1-ийн ТХХТ-ийн зарчмаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Стратегийн орд газруудыг холбосон төмөр замын сүлжээг барьж байгуулах, төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- 8.5-ын Улаанбаатар хотод шинээр барих 6 гүүрэн гарцын ажил БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжихээр 3 ажилд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ хийсэн, үлдсэн ажлуудын гүйцэтгэгчийг шалгаруулах ажил явагдаж байхад энэ ажлыг “Гудамж” төслийн хүрээнд хийхээр шийдвэрлэсэн⁷;
- 8.7-д тусгагдсан Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн шинэ төрөл систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх.

2.12 Төсвийн тухай хуульд хөрөнгө тусгагдаагүйгээс БХБЯ-ны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна. Үүнд:

- 7.2.1-ийн "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд 100 мянган айлын орон сууцыг барих ажлыг үргэлжлүүлэх хүрээнд "Шинээр 180 өрхийн ахмадын орон сууц барих;
- 7.2.2-ын Түрээсийн 396 айлын орон сууцыг гадна инженерийн шугам сүлжээний хамт барьж эхлүүлэх;
- 7.2.4-ийн Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх, сувилах эмнэлэг бүхий тусгай зориулалтын орон сууцны зураг төсөв боловсруулах;
- 7.4-ийн "Сум дундын төв" загвар төслийг хэрэгжүүлэх.

2.13 Мөн тендер оройтсон, шалгаруулалт хүчингүй болж дахин зарлагдсанаас дараах дэд арга хэмжээ хэрэгжээгүй, хугацаа алдаж байна. Үүнд:

- 7.1.1-ийн Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах;
- 8.36-гийн Дорнод аймгийн төвийн "Залуус хороолол"-ын дэд бүтцийг барих;
- 8.6.14 Улаанбаатар, Багахангай дүүргийн цэвэр, бохир усны шугам сүлжээ, усан сан, насосны станц, цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх.

2.14 Харин газрын асуудал шийдэгдээгүй, зураг төсөл боловсруулагдаагүйгээс доорх арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна. Үүнд:

- 7.2-ын Шинээр барих ахмадын орон сууцны газар шийдэгдээгүй;
- 8.6.2-ын Завхан аймгийн Улиастай хотын XXI зуун хорооллын гадна цэвэр бохир ус, дулаан, цахилгааны шугам сүлжээг барих ажлыг эхлүүлэх, зураг төсөл;
- 8.6.11-ийн Дархан-Уул аймгийн Шарын гол сумын цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх ажил зураг, төсөлгүй байна.

⁷ Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 30-ны 127 дугаар тогтоол

ТЕЗ-дын хамтач ажиллагаа дутмагаас хэрэгжилтэд нөлөөлж байна

2.15 Хамтран хэрэгжүүлэгч яамдын ажлын зохион байгуулалт уялдаа холбоо муу байгаагаас шалтгаалан хэрэгжилт удааширсан арга хэмжээ нэлээд байна. Тухайлбал,

- 2.1-ийн Уул уурхайгаас орох орлогыг зохистой ашиглах, хуримтлуулах асуудлыг нийгмийн даатгалын шинэчлэлтэй уялдуулан хэрэгжүүлэх;
- 8.12-ийн Улаанбаатар хотод Их тойруу 220, 110 кВ-ын цахилгаан дамжуулах дэд станц болон ДЦС-5 барих ажлыг эхлүүлэх;
- 8.5-ийн Улаанбаатар хотод шинээр авто зам, гүүрэн гарц барих, өргөтгөх ажлыг зохион байгуулах;
- 8.19-ийн Сайншандын салхин паркийг барьж, төвийн эрчим хүчтэй холбох;
- 8.15-ийн Улаанбаатар хотод улирлын горимоор ажиллах дулааны эх үүсвэр барих, хязгаарлалтын бүсийн гэр хорооллын айл өрхүүдийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийн биелэлт удаашралтай явагдаж байна.
- 11.1-ийн Агаарын бохирдол, орчны доройтлыг бууруулж, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэн, газар нутгийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг бэхжүүлэх,
- 17.2-т тусгагдсан Үйл ажиллагааг нь цахим хэлбэрт шилжүүлэх эмнэлгийн тоог нэмэгдүүлэх ЭМЯ-ны хариуцсан ажил ЭЗХЯ-наас зээлийн тусгайлсан гэрээг байгуулах ажил удааширснаар гэрээ хийгдээгүй байна.
- Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 122 тогтоолоор ХЗЯ-ны харьяа “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг”, БХЯ-ны харьяа “Зэвсэгт хүчний клиникийн төв госпиталь”-г нэгтгэн “Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг” болгон өөрчлөн зохион байгуулж, БХЯ-ны харьяанд ажиллуулах болсон ч 17.5-ын “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн барилгын ажлыг дуусгаж, тоног төхөөрөмжөөр хангах” арга хэмжээг үндсэн чиглэлд батлагдсан шалгуураар үнэлэх боломжгүй болсон.

2.16 Улсын Их Хурлаас баталсан үндсэн чиглэлд эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий зорилт, арга хэмжээг хэрэгжүүлсэн байхаар баталсан ч Засгийн газраас “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлаагүй, салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд хэрэгжилтийг зохион байгуулах тодорхой арга хэмжээг эрчимтэй авч чадаагүй, төлөвлөгөө боловсруулах ажилд хугацаа алдсан нь ихэнх арга хэмжээний хэрэгжилтэд нөлөөлж байна.

2.17 Хэрэгжүүлэгч байгууллагууд зорилт, арга хэмжээний хэрэгжилт дутуу, хангалтгүй байгаагийн шалтгааныг хөрөнгө санхүүтэй холбон тайлбарлаж байгаа ч төлөвлөлтийн шатанд хөрөнгө, санхүүгийн хэрэгцээ бүхий санал болгосон арга хэмжээг эрэмблээгүй, ач холбогдлыг үнэлээгүй, ихэнх арга хэмжээний үндэслэл судалгаа, тооцооллыг хийх бэлтгэл ажил хийгдээгүй, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үе шатны ажлын зохион байгуулалт сул, идэвхигүй хандсан байна.

Томоохон зорилт арга хэмжээний биелэлт хангагдаагүй байна

2.18 ТХХТ-ийн зарчмаар болон хувийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх арга зам, загвар тодорхойгүй, хэрэгжилт нь удаашралтай байна.

Тухайлбал, 18.4.1-ын *Аймаг, сум, дүүрэг, паркийн бүсэд "Үйлдвэрлэлийг дэмжих загвар төв" байгуулах гэсэн арга хэмжээний хэрэгжилт удаашралтай, санхүүжилт, хэрэгжүүлэх арга зам, загвар тодорхойгүй байна.*

2.19 ТЭЗҮ болон зураг төсөл бэлэн болоогүй, худалдан авах ажиллагаа оройтсон зэрэг шалтгаанаар зарим ТЭЗ-дын хариуцсан арга хэмжээ үр дүнтэй хэрэгжээгүй байна. Тухайлбал,

- 3.6.1-ийн *Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах ажлын санхүүжилт шийдвэрлэгдээгүйгээс хэрэгжээгүй байна.*
- 3.7-ийн *Зүүн бүсийн холимог металлын ордын түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулах судалгаа хийх ажлын төсөв 2013 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын жагсаалтад "Зүүн бүсийн холимог металлын ордын түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулах" нэрээр 100.0 сая төгрөг батлагдсан ч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах явцад Засгийн газрын 2013 оны 324 дүгээр тогтоолоор санхүүжүүлэх боломжгүй болсон байна.*
- 5.11.2-ын *Хүнсний ногооны таримлын үйлдвэр байгуулагдаагүй байна.*
- Мөн 5.11.5-ын *Дархан-Уул аймагт ТЭДС-ийн агуулахын цогцолбор байгуулагдаагүй байна.*
- 6.2.1-ийн *Үйлдвэрлэл технологийн паркийн бүсийн кластер, хөнгөн үйлдвэрийн туршилтын үйлдвэрийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, ХААГ зөвлөх үйлчилгээний тендер зарлан үнэлгээг хийж, 2013 оны 09 дүгээр сарын 17-ны 7/3652 тоот албан бичгээр "Үйлдвэрлэл технологийн паркийн бүсийн кластер, хөнгөн үйлдвэрийн туршилтын үйлдвэрийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах" зөвлөхийг сонгон шалгаруулсан ч улсын төсөвт хүндрэл үүсч, ажил хойшлогдоод байна.*
- 6.3.2-ын *Оёдлын үйлдвэрийн кластер хөгжүүлэх судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажил хийгдээгүй.*
- 6.3.3-ын *Ноос, ноолуурын салбарын үйлдвэрлэл-технологийн парк байгуулах судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээний тендер зарлан "Цагчиг-Цогт" ХХК, Монголын мэргэшсэн инженерүүдийн нийгэмлэг ТББ-ын түншлэл шалгарч уг үйл ажиллагааг гүйцэтгүүлэх ҮХААЯ-ЗҮ-2013.06.28-001 тоот гэрээ байгуулснаас өөр ажил хийгдээгүй байна.*

Оршил

3.1 Аудитын 3 дугаар дэд зорилт нь “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд биелэлт, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж үр дүнг тооцон ажиллаж буй эсэхийг үнэлж дүгнэхэд оршиж байв.

ЭЗХЯ 2013 оны “Үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг 73.4 хувь гэж үнэлжээ

3.2 ЭЗХЯ-наас улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх “Үндсэн чиглэл”-ийн биелэлтийг “73.4” хувь, ЗГХЭГ “67.1” хувь гэж үнэлжээ. Хэрэгжилтийн үнэлгээг бодлогын хамрах хүрээгээр харуулбал:⁸

Хүснэгт №3.1 /тоо, %/

Бодлогын хамрах хүрээ	Үндсэн чиглэл		Үнэлгээ	
	зорилт	арга хэмжээ	ЭЗХЯ	ЗГХЭГ
I. Өсөлтийн үр шимийг нийгмийн бүх бүлгүүдэд хүргэх макро эдийн засгийн	2	10	80.0	70.7
II. Бодит салбарын хөгжлийн бодлого	7	59	70.0	64.8
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого	3	18	75.6	56.2
IV. Хүнд өгөөжтэй нийгмийн бодлого	7	37	81.6	72.2
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэл	5	26	66.5	65.4
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах	2	16	76.3	76.9
Дүн	26	166	73.4	67.1

3.3 Нийт 166 арга хэмжээнээс бүрэн биелсэн 38 /22.9%/, 80-99 хувийн биелэлттэй 46 /27.7%/, 60-79 хувийн биелэлттэй 35 /21.1/, 40-59 хувийн биелэлттэй 25 /15.1%/, 20-39 хувийн биелэлттэй 19 /11.4%/, 0-19 хувийн биелэлттэй 1, харин 2 арга хэмжээг хангалтгүй биелэлттэй гэж үнэлэгджээ.


3.4 Хангалтгүй буюу хэрэгжээгүй гэсэн арга хэмжээг авч үзвэл “Бодит салбарын хөгжлийн” болон “Төрийн үйлчилгээ засаглал, эрх зүйн шинэчлэлийн бодлого”-ын хүрээний доорх арга хэмжээг нэрлэжээ. Үүнд:

- *Үндсэн чиглэлийн 9.2-т батлагдсан МТШХХГ-ын хэрэгжүүлэх “Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг нийслэл, 4 аймагт байгуулах” гэсэн арга хэмжээ байгууллагын 2013 оны төсвийн хүрэлцээгүйгээс хасагдсан.*
- *Мөн 20.2-т тусгагдсан ЗГХЭГ, ҮХШХ болон ЗТБХБЯ /хуучнаар/-ны хариуцсан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийн асуудал хариуцсан түр зөвлөлийг байгуулж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах” гэсэн арга хэмжээг Шинэчлэлийн Засгийн газраас 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө энэ чиглэлээр асуудал дэвшүүлээгүй гэсэн тайлбар өгчээ⁹.*

⁸ Эх сурвалж: Эдийн засгийн хөгжлийн яам

⁹ ЗГХЭГ-ын 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн ХЭГ/346 дугаар албан бичиг

Макро түвшний зарим үзүүлэлт бүрэн биелэгдээгүй байна



3.5 Үндсэн чиглэлд тусгагдсан макро түвшний эдийн засаг, нийгмийн зарим үзүүлэлтийн биелэлтийг авч үзвэл:¹⁰
Хүснэгт №3.2 /тоо, %/

Д.д	Агуулга	Шалгуур үзүүлэлт	Зорилт, арга хэмжээний	
			хүрэх түвшин	биелэлт
1.1	Эдийн засгийн өндөр өсөлтөд иргэд, нийгмийн бүлгүүдийн оролцоог дэмжих, дундаж давхаргын эзлэх хувийг нэмэгдүүлэх;	ДНБ-ний бодит өсөлт	19.0	11.7
		1 хүнд ногдох ДНБ	4,930 ам.долл	3,972
		1 хүнд ногдох ҮНБ	4730 ам.долл	Гараагүй
		ӨЧҮ	4.0 нэгж	3.7
		Ажилгүйдлийн түвшин	6.1	7.8
		Жини коэф.	0.34-өөс ихгүй	0.25
1.2	Бодит эдийн засаг, мөнгө, санхүүгийн харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, инфляцийн түвшинг хэт өсгөхгүй байх;	Жилийн дундаж хэмжээ	8.0 %-иас ихгүй	10.5
		Бэлтгэх шатахууны нөөц	20 хоногоос дээш	19
		Бэлтгэх нөөцийн мах	12.0 мян.тн	11.4
1.3	Төсвийн шинэтгэлийг үргэлжлүүлж, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ төсвийн зохистой харьцааг хадгалах;	ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх %	39.2	33.5
		ДНБ-д төсвийн зарлагын эзлэх %	41.2	35.2
		ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь	2.0	- 1.7
1.5	Эдийн засгийн өндөр өсөлтийг дэмжих томоохон төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, гадаад худалдааны алдагдлыг бууруулах, гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх	Гадаад худалдааны тэнцлийн ДНБ-д эзэлх хувь	5.5	- 18.0
		Гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ	22.7 долоо хоногийн импортын хэрэгцээг хангах	20.0

3.6 Үндсэн чиглэлд хийсэн сүүлийн жилүүдийн судалгаагаар урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг, үндсэн чиглэлд тусгагдсан ДНБ-ий өсөлт болон төсвийн бодлогын зорилт бүрэн хэрэгжээгүй байна.

3.7 Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5,880.7 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6,178.0 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 297.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

3.8 Хэрэглээний үнийн индекс өмнөх оны эцсийнхээс 12.5 хувиар өссөн нь эдийн засагт сөрөг үр дагаврыг дагуулж байгаа бөгөөд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо оны эцэст 42.8 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 19.6 хувиар өсчээ.

¹⁰ Эх сурвалж: Эдийн засгийн хөгжлийн болон Сангийн яам, Үндэсний статистикийн хороо "Урьдчилсан гүйцэтгэл"

3.9 ДНБ-ий өсөлт 2013 онд 11.7 хувьтай гарсан нь өмнөх оноос буурсан бөгөөд хүрэх түвшнээс 7.3 хувиар бага гарчээ.

- Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 3972 ам.доллар байгаа нь өмнөх оноос бага зэрэг өссөн боловч зорилтот түвшинд хүрч чадаагүй байна.
- Ажилгүйдлийн түвшин 7.8 хувьтай гарсан нь өмнөх оноос 1.7 пунктээр илүү буюу ажилгүйдэл нэмэгджээ.
- 2013 оны жилийн инфляци өмнөх оны жилийн эцсийн зорилтот түвшнээс 4.5 пунктээр илүү байна.
- ДНБ-д нэгдсэн төсвийн алдагдлын эзлэх хувь 2012 онд 6.9 хувь байсан бол 2013 онд зорилтот түвшинд хүрээгүй байна.
- Ядуурлын түвшин 29.8 хувьтай байна

3.10 Үндсэн чиглэлд тусгагдсан дээрх зорилт, арга хэмжээний 2013 онд хүрэх түвшин, үр дүнд хүрч чадаагүй, зарим үзүүлэлтийн гүйцэтгэл гараагүй нь ТЕЗ-даас энэ чиглэлээр хийсэн ажлын үр дүнгийн үнэлгээг бууруулах нэг шалтгаан, урьдчилсан нөхцөл болж байна.

3.11 Түүнчлэн 2013 онд хүрсэн байх түвшин, үр дүнгийн зарим үзүүлэлтийн гүйцэтгэл зорилтот түвшинд хүрч чадаагүй, өмнөх оны түвшинтэй харьцуулахад эдийн засгийн ерөнхий үзүүлэлт буурч, өсөлт саарсан байна. Тухайлбал,

Шалгуур үзүүлэлт	Он	Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Бодлогын хэрэгжилт
ДНБ-ий бодит өсөлт /%-иар/	2010*	7.4	6.1	"Үгүй"
	2011*	8.2	17.3	"Тийм"
	2012*	16.6	12.3	"Үгүй"
	2013**	19.0	11.7	"Үгүй"
ДНБ-д нэгдсэн төсвийн зарлагын эзлэх хувь	2010*	38.8	37.3	"Тийм"
	2011*	40.4	44.3	"Үгүй"
	2012*	36.5	42.5	"Үгүй"
	2013**	39.0	35.2	"Тийм"
ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь	2010*	5.0	0.5	"Тийм"
	2011*	5.0	5.8	"Үгүй"
	2012*	6.7	7.6	"Үгүй"
	2013**	2.0	- 1.7	"Үгүй"

Тайлбар: *Өмнөх аудитын дүн, **Урьдчилсан гүйцэтгэл

3.12 Үндсэн чиглэлийн 2013 оны хэрэгжилтийг өмнөх жилүүдтэй харьцуулбал,

Үзүүлэлт	2010 он		2011 он		2012 он		2013 он	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хэрэгжсэн	152	32.1	56	29.4	17	11.7	55	33.1
Хэрэгжилт дутуу	305	64.5	120	63.2	120	82.8	101	60.8
Хэрэгжээгүй	16	3.4	14	7.4	8	5.5	10	6.0

Тодруулга: 2013 оны биелэлтийн дүнд хэрэгжсэн арга хэмжээ 33.1 хувьтай байгаа бөгөөд түүнийг өмнөх онуудтай харьцуулахад 2012 оноос 21.4 пунктээр, 2011 оноос 3.7 пунктээр, 2010 оноос 1.0 пунктээр тус тус өссөн эерэг үзүүлэлт харагдаж байгаа боловч нийт арга хэмжээний дүнд 33.1 хувь, хэрэгжилт дутуу болон хангалтгүй биелэлттэй арга хэмжээ 66.8 буюу дийлэнхи хувийг эзэлж байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатайг харуулж байна.

Яамдын ХШҮ-ний нэгжээс хийсэн үнэлгээний дундаж 66.7 хувь байна

3.13 ТЕЗ-даас ирүүлсэн тайлагнал, биелэлтэд ЭЗХЯ-ны өгсөн үнэлгээ болон ҮАГ-аас арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, тайлагналтай харьцуулан дүгнэснийг хариуцагч байгууллагуудаар харуулбал:

Хүснэгт №3.5

/дундаж хувь, тоо/

Хариуцагч	Үнэлгээ		Аудитлагдсан			
	Яамд	ЭЗХЯ	Үнэлгээ	Арга хэмжээ		
				хэрэгжсэн	дутуу	хэрэгжээгүй
ЭЗХЯ	63.4	68.7	60.0	1	7	-
СЯ	90.5	91.2	79.4	2	3	-
ХАХНХЯ	78.0	68.6	70.3	3	4	-
БХБЯ	70.2	76.7	62.8	3	7	1
ХЯ	85.4	87.5	75.3	4	4	-
ГХЯ	78.0	73.8	73.0	2	5	-
ХЗЯ	79.4	63.3	64.0	1	10	-
БШУЯ	91.9	85	81.0	8	8	-
ЗТЯ	68.9	68.9	57.0	2	6	1
ССАЖЯ	83.1	90	83.1	1	1	-
УУЯ	80.6	70.7	60.5	2	9	-
ҮХААЯ	73.5	79.2	67.3	8	7	-
ЭХЯ	81.2	71.1	78.0	4	5	1
БОНХЯ	81.7	76.5	75.3	4	10	1
ЭМЯ	70.0	85	65.1	1	3	-
БХЯ	70.0	75.6	60.0	1	8	-
ШСАА	63.3	-	60.0	2	2	1
МБанк	100	-	90.0	1	-	-
СЗХ	77.5	-	73.0	1	1	-
МТШХХГ	46.0	-	37.0	3	-	3
ШЕЗ	-	-	-	-	1	-
ҮАГ	-	-	-	-	-	1
ЗГХЭГ	-	-	-	-	-	1
Дүн	66.7	73.4	59.0	55	101	10

ТЕЗ-дын үнэлгээ аудитаар 7.7 пунктээр буурч байна

3.14 Үндсэн чиглэлийн биелэлтийн байдалд ТЕЗ-даас өгсөн үнэлгээнд ҮАГ-аас хийсэн үнэлгээний дундаж 59.0 хувь буюу 7.7 пунктээр буурч байна.

3.15 Үндсэн чиглэлд ТЕЗ-дын хамтран 72, дангаар хэрэгжүүлэх 94 зорилт, арга хэмжээ байгаа бөгөөд нийт 166 арга хэмжээнээс хэрэгжсэн 55 буюу 33.1 хувь, хэрэгжилт дутуу 101 буюу 60.8 хувь, хэрэгжээгүй 10 буюу 6.1 хувийг эзэлж байна.

3.16 Зорилтот түвшинд хүрээгүй болон биелэлт нь хангагдаагүй зорилт, арга хэмжээний шалтгаан, нөхцөл, үр дагаврын хамрах хүрээг тооцож үнэлээгүй, хэрэгжүүлэлтийн явцад гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн зохион байгуулалтын ажил дутмаг байна.

Бодит салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилт хангалтгүй байна

3.17 Үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын хүрээний зорилтуудын хэрэгжилтийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №3.6

/тоо/

Бодлогын хамрах хүрээ	Хэрэгжилтийн байдал, Үүнээс			
	хэрэгжсэн	хэрэгжилт дутуу	хэрэгжээгүй	
I. Өсөлтийн үр шимийг нийгмийн бүх бүлгүүдэд хүргэх макро эдийн засгийн бодлого:	Тоо,	3	7	-
II. Бодит салбарын хөгжлийн бодлого:	Тоо,	22	33	6
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого:	Тоо,	6	11	1
IV. Хүнд өгөөжтэй нийгмийн бодлого:	Тоо,	18	18	-
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн бодлого:	Тоо,	3	19	3
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах:	Тоо,	3	13	-
Дүн		55	101	10

3.18 Бодлогын зорилтоор ангилан авч үзэхэд эдийн засагт гол дэмжлэг үзүүлэн бизнесийн таатай орчныг буй болгох чиглэлээр буюу бодит салбарын хөгжлийн, хүнд өгөөжтэй нийгмийн, төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээний арга хэмжээний биелэлт хангалтгүй байна.

3.19 Үндсэн чиглэлд тусгагдсан бодит салбарын хөгжлийн бодлогын нийт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний 50.0 илүү хувь хэрэгжилт хангагдахгүй байгаагаас эдийн засагт бодит өсөлт гарахгүй, хөгжлийн үзүүлэлт буурсан байна.

3.20 Эдийн засагт хамгийн их нөлөө үзүүлэх бодит салбарын асуудлыг хариуцдаг ЭЗХЯ, УУЯ, ЭХЯ, БХБЯ, ҮХААЯ зэрэг яамдын хариуцан хэрэгжүүлэх үндсэн чиглэлийн арга хэмжээний хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийхэд томоохон зорилт, арга хэмжээ хангалттай хэрэгжээгүй дүнтэй байна.

3.21 Бодит салбарын хөгжлийн бодлогын эдгээр арга хэмжээний хэрэгжилт ЭЗХЯ-ны дүгнэснээр 70 хувьтай, аудитлагдсан дүнгээр 54.0 хувьтай байгаа нь хангалтгүй үзүүлэлт бөгөөд цаашид хэрэгжилтэд онцгой анхаарч тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

3.22 Сангийн яам, ЭЗХЯ нь үндсэн чиглэлийн биелэлтийг гаргахдаа “Төсвийн шинэтгэлийг үргэлжлүүлж, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ төсвийн зохистой харьцааг хадгалах зорилтын хүрээний биелэлтийг тайлагнахдаа ДНБ-д эзлэх төсвийн хүрсэн түвшний үзүүлэлтийг бус УИХ-аар баталсан тодотголын үзүүлэлтийг бичиж биелэлтийг 100 хувь гэж тайлагнасан байна.

Үр дүнд чиглэсэн төлөвлөлтгүйгээс гүйцэтгэлд нөлөөлж байна

3.23 ТЕЗ-ын хариуцсан зорилт, арга хэмжээнээс дараах асуудлууд хэрэгжээгүй гэж дүгнэгдэж байна.

Тухайлбал,

- 7.1-ийн “Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулж дуусгах ажлын тендерийг БХБЯ-наас 4 удаа зарлан тендерийн үнэлгээг хийхэд ирүүлсэн материалууд шаардлага хангаагүй ба хөрөнгийн эх үүсвэр нь 2013 оны улсын төсвийн тодотголоор хасагдсан тул тендер шалгаруулалт зогсож үргэлжлүүлэх боломжгүй болжээ.
- 8.2-ын ЗТЯ-наас Улаанбаатар хотод ачаа тээврийн нэгдсэн терминал байгуулах бэлтгэлийг хангах хүрээнд холимог тээврийн нэгдсэн терминалыг Хөшигийн хөндий дэх шинэ нисэх онгоцны буудлын дэргэд байгуулахаар тохиролцон, байршлыг Улаанбаатар хотын 2020 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөнд тусгуулсан ч хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна.
- 8.19-ийн ЭХЯ-наас Сайншандын салхин паркийг барьж, төвийн эрчим хүчтэй холбох ажлын хүрээнд “Сайншанд салхин парк” ХХК нь Дорноговь аймгийн Сайншанд суманд 50 МВт хүчин чадалтай салхин цахилгаан станц байгуулах ажлыг хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа бөгөөд салхин паркийн талбайгаас Сайншандын 110/35/10 кВ-ын хаалттай дэд өртөө хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугамын газрын асуудал шийдвэрлүүлж чадаагүй байна.
- 9.2-ын МТШХХГ-аас тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг нийслэл 4 аймагт байгуулах төслийн ТЕЗҮ боловсруулсан ба тус төслийн санхүүжилтийн саналыг улсын төсвөөр шийдвэрлүүлэхээр Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2013 оны төсвөөс хасагдсан байна.
- 9.4-ийн МТШХХГ-аас шуудангийн салбарт шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэхэд электрон хэвлэлийг хувилах тоног төхөөрөмжийг 10 аймагт суурилуулахаар байсан боловч 2013 оны төсөвт хөрөнгө оруулалтын эх үүсвэр батлагдаагүйгээс хэрэгжээгүй байна.
- 9.5-ын МТШХХГ-аас цахим гарын үсэг, цахим нэг цонхыг төрийн бүх үйлчилгээнд нэвтрүүлж, цахим технологид тулгуурласан төрийн үйлчилгээг өргөтгөх хүрээнд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд шилжүүлэх судалгаа хийж, төслийн танилцуулга бэлтгэгдэж, ЗГХЭГ-т ажлын хэсэг байгуулагдсанаар уг ажил эхлэлийн төдий байна.

- 10.8-ын БОНХЯ-ны хийх элэгдэж, эвдэрсэн газрын хөрсний нөхөн сэргээлтийг 1.65 мян га талбайд хийхээс 143.5 га газарт нөхөн сэргээлт хийхээр БОНХЯ-наас ажлын даалгавар боловсруулж ХААГ-т хүргүүлсэн боловч тендерийн материал шаардлага хангаагүй учир тендер зарлагдаагүйгээс энэ ажил хийгдээгүй.
- 20.2-ын ЗГХЭГ, ҮХШХ болон ЗТБХБЯ/хуучин нэрээр/-ны хариуцсан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийн асуудал хариуцсан түр зөвлөлийг байгуулж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах” гэсэн арга хэмжээг Шинэчлэлийн Засгийн газраас 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө энэ чиглэлээр асуудал дэвшүүлээгүйгээс хэрэгжээгүй.
- 20.3-ын ШСАА хариуцсан МХЕГ-ын төв байр, аймаг, нийслэлийн дүүргүүд, хилийн боомт дахь мэргэжлийн хяналтын байгууллагыг ажлын болон лабораторийн байраар хангахаар төлөвлөсөн боловч МХЕГ-ын төв байр, хилийн 6 боомт дах барилгын ажлын хөрөнгө 2013 оны нэгдсэн төсөвт тусгагдаагүйгээс хэрэгжээгүй, 5 аймаг, дүүргийн МХА-ны шинэ барилга барихаас Ховд аймгийн МХГ-ын лабораторийн барилга барихад зориулж 2013 оны төсөвт 400.0 сая төгрөг тусгагдсан боловч санхүүжилт зогссон байна. Төв аймгийн МХГ-ын лабораторийн барилга барихад зориулж 2013 оны нэгдсэн төсөвт 300.0 сая төгрөг тусгагдан барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна.
- 20.6-гийн ҮАГ-аас төрийн байгууллагуудаас зохион байгуулах хурал, семинар, сургалт зэрэг арга хэмжээг олон улсын стандартын дагуу явуулах орчныг бүрдүүлэхээр сургалтын бааз барихад 2013 онд улсын төсвөөс 4.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санал өгсөн боловч батлагдаагүйгээс хэрэгжээгүй байна.

Төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг үнэлэх үнэлгээний тогтолцоог шинэ түвшинд гаргах шаардлагатай

3.24 Яамд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын шинж чанартай арга хэмжээнд тусгагдсан хөрөнгийг төсөвт тусгагдаагүй шалтгаан, төсөвлөгдсөн хөрөнгөөс хэдий хэмжээний хөрөнгө нь төсөвт тусгагдаж, тухайн арга хэмжээнд зарцуулсан тооцоо, гүйцэтгэлийн талаар тайлагналгүй үйл ажиллагааг дэлгэрэнгүй тоочсон байна.

3.25 Яамдын ХШҮДАГ-ууд биелэлтийг газар дээр нь очиж үзэх боломжгүй, зөвхөн тайлагналд үндэслэн мониторинг хийдэг тухайгаа ярилцлагын явцад илэрхийлж байна.

3.26 Түүнчлэн зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нэг бүрчлэн оновчтой тогтоодоггүй, хэрхэн хэмжигдэх нь тодорхойгүй байх, дахин дэвшигдсэн арга хэмжээний суурь болон өөрчлөлтийг хэмжих үзүүлэлтийг тодорхой болгох асуудалд цаашид анхаарах шаардлагатай байна.

3.27 Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхи сул хөгжсөн нь хэрэгжилтийг тайлагнасан байдлаас ажиглагдаж байгаа бөгөөд тайлагнал бодитой бус, давтагдах, харгалзах шалгуур үзүүлэлтээр баталгаажуулж үнэлгээ дүгнэлт өгөхгүй байна.

3.28 Зорилт, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ биелэлтийн үр дүнг үндэслэн урамшуулал, хариуцлагын асуудлыг авч үзэх, оролцооны аргаар хяналтыг хэрэгжүүлэхэд биелэлтийн явцад дүн шинжилгээ хийж үнэлгээ өгдөг байхуйц ХШҮ-ний тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Үндсэн чиглэлийн хэрэгжилттэй холбогдуулан гарсан шийдвэрийн биелэлт хангалтгүй байна

3.29 УИХ-ын 2013 оны “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолд “дутуу хэрэгжсэн болон хэрэгжээгүй зорилт, арга хэмжээг эдийн засаг, нийгмийн ач холбогдол, хэрэгцээ шаардлагаар эрэмбэлж биелэлтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч дүнг УИХ-д танилцуулах үүргийг Засгийн газарт өгсөн ч хэрэгжилт яамдын түвшинд хангалтгүй байна.

3.30 ҮАГ-аас 2012 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдалд аудит хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар ТЕЗ нар хангалттай ажил зохион байгуулаагүй бөгөөд ЭЗХЯ-наас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнасан байдлаас үзэхэд үндсэн чиглэлийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлж байна.

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Төлөвлөлтийн талаар:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг 2012 оны 5 дугаар сард баталсан бөгөөд 2013 оны төсвийн тухай хуулинд уг үндсэн чиглэлд тусгагдсан зарим арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг тусгаагүй байна.
- Энэхүү үндсэн чиглэлийг шинэ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулж зохих тодотгол, өөрчлөлтийг оруулаагүй байна.
- Үндсэн чиглэлд зайлшгүй хэрэгцээ шаардлага бүхий зорилт, арга хэмжээг тусгах буюу тэдгээрийг боловсруулах зохистой арга зүйг тогтоох замаар төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах шаардлагатай байна.
- ЭЗХЯ үндсэн чиглэлд тусгах зорилт, арга хэмжээг анхан шатанд боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхгүй, төлөвлөлтөд үнэлгээ дүгнэлт өгөхгүй байгаа нь хэрэгжих үндэслэлийг бууруулж байна.

Хэрэгжилтийн талаар:

- Аудитын дүнгээр үндсэн чиглэлийн 166 зорилт, арга хэмжээний биелэлтийг тогтоосон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй харьцуулбал хэрэгжсэн 55, дутуу хэрэгжсэн 101, хэрэгжээгүй 10 арга хэмжээ буюу үнэлгээ 59.0 хувьтай байна.
- Сангийн яам, ЭХЯ, БХБЯ, ХЗЯ, ҮХААЯ, ХАХНХЯ, БОНХЯ, ССАЖЯ үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнд нь анхаарч ажиллажээ.
- ЭЗХЯ, ЗТЯ, ЭМЯ, БШУЯ, УУЯ, ГХЯ, Хөдөлмөрийн яам үндсэн чиглэлд заасан арга хэмжээг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгажээ.


Тайлагнал, үнэлгээний талаар:

- Яамд, агентлагууд зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа тодорхой бус, тоочих байдлаар гарган түүнд ЭЗХЯ үнэлгээ өгч байна.
- Харин яам агентлагын ХШҮДАГ-ууд үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг үнэлэх ажлыг сайжруулах шаардлагатай байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

**Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга
Ч.Сайханбилэг, Эдийн
засгийн хөгжлийн сайд
Н.Батбаяр нарт:**



**Төсвийн ерөнхийлөн
захирагч нарт:**

- Үндсэн чиглэлийн төслийг боловсруулах зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгож мөрдөх,
- Үндсэн чиглэлд хөгжлийн бодлогын эн тэргүүний зорилт, арга хэмжээг тусгаж байхаар салбар хариуцсан яамдыг чиглүүлж ажиллах,
- Үндсэн чиглэлд Засгийн газрын дунд хугацааны хөтөлбөрт тусгагдсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан асуудлыг тусган хэрэгжүүлж байх,
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланд зорилт, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг тодорхой тусгаж байх,
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд дэмжлэг үзүүлэн бие даасан хараат бус байдлыг хангуулж, чадавхи, зохион байгуулалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдаад хэрэгжээгүй байгаа асуудалд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах,
- ЗГҮАХ болон бодлогын бусад баримт бичигтэй уялдуулан үндсэн чиглэлд тусгах салбарын зорилт арга хэмжээг оновчтой сонгож, хэрэгжилтэд чиглэсэн арга хэмжээг үр нөлөөтэй зохион байгуулж байх,
- Үндсэн чиглэлийн төлөвлөлтөөс эхлүүлэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшинг үр дагавартай нь харьцуулах, үр дүнгийн хамрах хүрээг тогтоон бодитой үнэлж, тайлагналыг боловсронгуй болгох.

Холбогдох байгууллагын санал:

Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛС ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 14 он 05 дугаар
сарын 02 ны өдөр

Дугаар ... ХЭГ/795

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар 1.1-ийг үзнэ үү.

Дүгнэлт, зөвлөмжид санал өгөх тухай

Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас хийсэн дүгнэлт, зөвлөмжтэй танилцаад, УАГ-ын дүгнэлтийн сайжруулах асуудал "ЗГХЭГ, ЭЗХЯ, бусад ТЕЗ-даас баримт бичгийн биелэлтийг хангахад гарч буй зардлын үр ашиг, үр дүнг тооцох арга зүйг боловсруулан ашиглах, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхийг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажиллахгүй байна" гэсэн хэсэг, 3.26 дахь хэсгийг тус тус хасуулах саналтай байна.

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас хийсэн дүгнэлт, зөвлөмж болон УИХ-ын 2013 оны 35 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн даалгаврыг биелүүлэх талаар ЗГХЭГ дараах арга хэмжээ авч ажилласан.

1. Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам", "Журамд нэмэлт оруулах тухай" 2009 оны 285 дугаар тогтоол, 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ууд нь Засгийн газрын бүтэц шинэчлэгдсэнтэй холбоотойгоор зарим заалт нийцэхгүй болсон, олон тайланг давхардуулан гаргаж, төлөвлөлт, тайлагналын ойлгомжгүй, хэт нүсэр байдлыг бий болгож байсан зэрэг сөрөг үр дагаварыг үүсгэж байсанд дүгнэлт хийж ажиллав.

Иймд эдгээр журмуудыг нэгтгэн, шинэчлэн найруулж Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 21-ны өдрийн 322 тогтоолоор "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-ыг баталж, хэрэгжүүлж байна.

2. ЗГХЭГ-аас "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем"-ийн буюу www.evaluation.gov.mn-ийг төрийн байгууллагуудад шинээр нэвтрүүлж байгаа бөгөөд энэхүү системийг ашигласнаар төрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнах ажиллагааг нэгдсэн тогтолцоонд шилжүүлэхэд чухал алхам болсон. ЗГХЭГ-т яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-аас тус бүр 400-700 хуудас бүхий тайлан, мэдээ ирүүлдэг байсныг өөрчилж, тайлант жил гүйцэтгэсэн ажлын явцыг үнэлж, дүгнэх ажлыг бодитой болгож, төсвийн төлөвлөлтийг гүйцэтгэлийн үр дүнтэй холбоход ахиц гаргахад чиглүүлж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал - “Үргэлжлэл

3. 2013 онд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг, үр дүнг нарийвчлан тооцох зорилгоор зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд жил бүрийн зорилтот түвшинг тодорхойлж, хүрсэн түвшин, үр дүнг нарийвчлан тооцох тогтолцоог шинээр бий болгов. Үүний үр дүнд Засгийн газрын 2014 оны 68 тоот тогтоолоор “Яамдын засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”, ЗГХЭГ-ын даргын 2014 оны 88 тоот тушаалаар “Аймаг, нийслэлийн засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийг тус тус баталж, салбарын бодлогын зорилтын суурь болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж, шинээр засаглалын болон авилгын эсрэг индексийн үзүүлэлтийг оруулав.

4. Түүнчлэн уг журмаар аудитын болон хяналтын байгууллагын өгсөн дүгнэлт, зөвлөмжийг ажил хэрэг болгож, хэрэгжүүлэх үүднээс “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-г боловсруулж, түүний дагуу авсан арга хэмжээг тайлагнаж байх зохицуулалт хийсэн нь төрийн үйлчилгээний шинэчлэлийн бодлогын хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэгдсэн бодит алхам болно гэж үзэж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ч.САЙХАНБИЛЭГ

Холбогдох байгууллагын санал:

Хоёр. Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн санал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: (976-51) 26-33-33, E-mail: info@med.gov.mn,
http://www.med.gov.mn

2014.05.02 № 1/851
танай 2014.04.21-ны № 647 -т

Санал хүргүүлэх тухай

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилт"-д танай байгууллагаас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

**Тайлбар 2.1-ийг
үзнэ үү.**

**Тайлбар 2.2-ыг
үзнэ үү.**

**Тайлбар 2.3-ыг
үзнэ үү.**

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг ЗГХЭГ-т хүргүүлсэн бөгөөд ЗГХЭГ-аас дахин үнэлгээ хийсэн болно. Иймд тайландаа үнэлгээний эцсийн хувилбараар мэдээллийг оруулах нь зүйтэй;

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл нь УИХ-ын 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор батлагдсан. Үндсэн чиглэлд тодотгол хийх эрхзүйн орчин бүрдээгүйгээс нэмэлт өөрчлөлт хийх боломжгүй байдаг. Иймд төслийн 1.26, 1.27-д туссан дүгнэлтийг өөрчлөх эсвэл хасуулах саналтай байна.

3. Мөн төслийн 2.9-д 1563.6 км зам ашиглалтанд оруулахаар төлөвлөн ажилласан гэж тусгасан байгааг дахин нягталж үзэх нь зүйтэй юм. Үндсэн чиглэлийн 8.5-д өргөтгөл, шинэчлэлт хийх авто зам 100 км гэсэн байгааг орхиж тооцсон байна.

Жич: Чингис бондын хөрөнгийн санхүүжилтийг Хөгжлийн банкаар дамжуулан хийхтэй холбогдон гарсан эрхзүйн зохицуулалтын талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,



0005

Саналд өгөх тайлбар:

Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар 1.1

Тайлангийн “Сайжруулах асуудал” болон 3.26 дах хэсэгт найруулгын өөрчлөлт хийв.

Саналд өгөх тайлбар:

Хоёр. Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар 2.1

Саналыг хүлээн авч ЗГХЭГ-аас улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн байдалд ТЕЗ-д болон ЭЗХЯ-ны үнэлгээнд дахин өгсөн үнэлгээний дүнг бодлогын үндсэн зорилтоор нь тайлангийн 3 дугаар бүлгийн 3.1 дэх хүснэгтэд нэмж оруулав.

Тайлбар 2.2

УИХ-аас баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам”-ын 7.8 дах хэсэгт “Төрийн захиргааны төв болон ... Үндсэн чиглэлд тусгасан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх явцад гарсан хүндрэлтэй асуудлыг судлан шийдвэрлэх арга замын талаар асуудал боловсруулан Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж болно” гэсэн байх тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

Тайлбар 2.3

ЭЗХЯ-наас ирүүлсэн уг санал нь Үндсэн чиглэлийн 8.5-д тусгагдсан дэд арга хэмжээ буюу “Улаанбаатар хотод шинээр авто зам, гүүрэн гарц барих, өргөтгөх ажлыг зохион байгуулах” зорилтын хүрээнд батлагдсан өргөтгөл, шинэчлэлтийн ажил учраас шинээр баригдах тооцоололд оруулаагүй болно.

Тайлангийн уг хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал:



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх “Үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засгийн хөгжлийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

Гурав. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2014 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засаг газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт нарт зөвөлсүгэй.

Дөрөв. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга С.Төмөрхүүд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

Тушьяг-2014 он

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Зорилт, арга хэмжээний дугаар	Зорилт, арга хэмжээний агуулга	Хариуцан хэрэгжүүлэгч /яам, газар, агентлаг, аймаг, нийслэл/
1	2	3	4
НЭГ. ӨСӨЛТИЙН ҮР ШИМИЙГ НИЙГМИЙН БҮХ БҮЛГҮҮДЭД ХҮРГЭХ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
Зорилт-1. Эдийн засгийн өсөлтийг оролцоотой, хүртээмжтэй болгоход чиглэгдсэн макро эдийн засгийн тэнцвэрт бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангана.			
1	1.3	Төсвийн шинэтгэлийг үргэлжүүлж, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ төсвийн зохистой харьцааг хадгалах;	СЯ
Зорилт-2. Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах санхүүгийн салбарын хөгжлийг олон улсын түвшинд ойртуулах бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.			
2	2.2	Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг эрчимжүүлэх;	СЯ, МУХБ
